



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 09 өдөр

Дугаар A/39

Биндэр сум

Авто тээврийн болон өөрөө явагч
хэрэгслийн урьдчилсан үзлэг явуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд авто тээврийн хэрэгслийн техникийн үзлэгийг 05 дугаар сарын 26-28-ний өдрүүдэд зохион байгуулсугай.


2.Авто тээврийн хэрэгслийн хяналтын үзлэгт ороогүй өөрийн нутаг дэвсгэрт байгаа бүх тээврийн хэрэгслийг бүрэн хамруулахыг багийн Засаг дарга нарт, үзлэгийн явцад авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлж бүрэн хамруулж ажиллахыг татварын улсын байцаагч (А.Уранчимэг)-т үүрэг болгосугай.

3.Суманд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг бүртгэлд хамруулах, бүртгэл тооллого, техникийн хяналтын үзлэг зохион байгуулах явцад замын хөдөлгөөнд зохицуулалт хийж ажиллахыг Замын цагдаагийн зохицуулагч, цагдаагийн ахмад (Д.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

4.Үзлэг оношилгооны дүнд хяналт тавьж үзлэгийн эцсийн дүнг 05 дугаар сарын 29-ний дотор танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (М.Отгонбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН



231000088